



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 06 өдөр

Дугаар A/347

Улаанбаатар хот

**Захирамжийн зарим хэсгийг хүчингүй  
болгож өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.7, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8, Төсвийн тухай хуулийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн Засаг даргын 2025 оны Эрх шилжүүлэх тухай A/219 дүгээр захирамжаар эрх шилжүүлсэн зарим ажил зураг төсөвгүй, холбогдох газраас зөвшөөрөл ирээгүй зэрэг нөхцөл байдлаас шалтгаалж хавсралтын 2, 3, 7, 9, 10 дахь хэсгийг хүчингүй болгож 8 дахь хэсгийн “Зуунмод цэцэрлэгт хүлээлэнгийн тохижилтын ажил” гэдгийг “Зуунмод цэцэрлэгт хүрээлэнгийн өндөржилтийн ажил” гэж өөрчлөлт оруулсугай.

2.Өөрчлөлт орсон ажлын гэрээ байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс (М.Цогтбилэг), гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс (Ц.Батжанцан)-т тус тус даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ